



# СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН


МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№45 /489/

2023.03.15

Тусгай дугаар

## "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР", ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 102 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН МЭНД ДЭВШҮҮЛЬЕ!



Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 5 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулж буй "Цэргийн андууд" дурсамж уулзалт 2 дах өдрөө ёслол төгөлдөр үргэлжилж байна.

Уг дурсамж уулзалтын хүрээнд өчигдөр бага дарга нар чуулж цэрэг ахуй насаа дурсан нэгэн өдрийг баяр хөөр дүүрэн өнгөрүүлсэн бол өнөөдөр Төрийн цэргийн байгууллагуудад ажиллаж буй офицер, ахлагч нар болон тэтгэвэр чөлөөндөө гарсан ахмадуудын төлөөлөл хүрэлцэн

иржээ. Мөн өнөөдрийн уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, ЗГХЭГ-ын дэд дарга Б.Энх-Амгалан, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо болон Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба тэргүүтэй Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд оролцож байна. Дурсамж уулзалтыг нээж

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх хэлсэн үгэндээ хүрэлцэн ирсэн офицер, ахлагч нар болон үеийн ахмадуудынхаа амрыг эрэн мэндчилээд Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийн баярын мэндийг дэвшүүлэн хүндэтгэл үзүүллээ.

Өнөөдрийн уулзалтад офицер, ахлагч нар болон тэтгэвэр чөлөөндөө гарсан ахмадуудын төлөөлөл болох 1000 гаруй хүмүүс оролцож байгаа бөгөөд дийлэнх нь уг арга хэмжээнд анх удаа оролцож

буйгаараа онцлог байна. Эл дурсамж уулзалтын хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын музейн үзэсгэлэнгүүд дэлгэгдэж үзэгч олны хүртээл болж байгаагийн зэрэгцээ ЦДБЭЧ, ХЦДБЭЧ, Цагдаагийн "Сүлд" чуулга, ШШГЕГ-ын Соёмбо чуулга, ЗХЖШ-ын ҮЖҮНХ-ийн уран бүтээлчид уран бүтээлийн дээжсээ өргөн барьж байна. Түүнчлэн мөр зэрэгцэн алба хааж явсан цэргийн андуудаа хүндэтгэж МУАЖ Д.Жаргалсайхан болон "Хурд", "Андууд", "Хар сарнай", "Fire" хамтлагууд ая дуугаа өргөхөөр иржээ.





ЦЭРГИЙН АНДУУД ДУРСАМЖ УУЛЗАЛТ-2023

ЗУРГИЙН ЦОМОГ



Дарга дэд хурандаа  
САЙНБОЛДЫН УУГАНБАЯР

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018  
Цахим шуудан:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)